



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-24-80, Факс: 32-31-58, 26-06-13  
E-mail: info@mecss.gov.mn, http www.mecss.gov.mn

2018. 06. 04 № 10/3047  
танай \_\_\_\_\_ -ны № 15 -т

Таны асуулгын хариу

Таны асуулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна

**АСУУЛГА**

**НЭГ. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын хүрээнд дээд боловсролын агуулга, стандарт, сургалтын чанарын үнэлгээг сайжруулж, чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийг олон улсын жишигт нийцүүлэн төгөлдөржүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ ба тодорхой үр дүнд хүрсэн эсэх тухай**

Монгол Улсын Засгийн газар 2016-2020 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөрт “Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ.” гэж тодорхойлсоны дагуу 2018 оны 1 дүгээр сард “Дээд боловсрол-Тогтвортой хөгжил” улсын зөвлөгөөнийг зохион байгуулж, тулгамдсан асуудлуудыг илрүүлэх, түүнийг шийдвэрлэх арга механизмыг тодорхойлсон.

Чанартай, сайн менежмент бүхий тэгш хүртээмжтэй дээд боловсролын тогтолцоог Монгол Улсад бий болгох их, дээд сургуулийн сургалтын үйл ажиллагааг сайжруулах, нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогоо тодорхойлон, дээд боловсролын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, сургалт, судалгааны үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна

Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанар харилцан адилгүй байна. Төрийн өмчийн сургууль, төрийн бус өмчийн сургуулийн чанар ялгаатайн дээр төрийн бус өмчийн сургуулиуд ч дотроо ялгаатай байна. Үйл ажиллагааны менежмент сайтай, хөгжлийн чиг хандлагад нийцсэн үр дүнтэй сургалт явуулж, хөрөнгө оруулалт хийж, чанартай судалгаа, шинжилгээ ажил эрхлэн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж буй сайн сургуулиуд байгаагийн зэрэгцээ дээд боловсролыг “бизнес” гэж харж буй сургуулиуд ч байсаар байна.

Иймээс дээд боловсролын хөтөлбөрүүдийн агуулга, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг нийгмийн эрэлт, шаардлагад нийцүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагад тавих шаардлагыг жигд баримтлах, магадлан итгэмжлэлийг зохих ёсоор нь явуулах, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үйл ажиллагааг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Үүнд:

### **Сургалтын чанарыг сайжруулах талаар:**

Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах, сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх, төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэх, үйл ажиллагааны чанарыг сайжруулахаар “Үр дүнд суурилсан боловсрол”-ын тогтолцоог хөгжүүлэх, чиглэл гарган ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхдээ хүрэх үр дүн, төсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, төлөвшил, хандлагыг ажил олгогчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан урьдчилан тодорхойлж, түүнд зориулан сургалтын агуулга, арга зүй орчноо сайжруулах, үнэлгээний аргачлалыг өөрчлөн, үр дүнгээ тасралгүй хянаж, чанарын баталгаажуулалтыг хийдэг цогц үзэл баримтлалыг хэрэгжүүлж байгаа юм.

Багш нарын сургалтын арга зүйг сайжруулах, хандлагыг өөрчлөх, их дээд сургуульд зааж байгаа хичээлийн агуулгыг оюутнуудад нээлттэй болгох, онлайн болон танхимын сургалтыг зөв хослуулах арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг идэвхтэй явуулж байна. Дээд боловсролын тэгш, хүртээмжтэй байдлыг хангах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хөдөө орон нутгийн их, дээд сургуулийг хөгжүүлэх зорилгоор “Зайн сургалтын төв” –ийг Дорнод, Ховд, Архангай, Завхан аймагт болон Улаанбаатар хотод МУБИС-ийг түшиглэн байгуулж, төвлөрсөн удирдлагаар ханган багшийн мэрэгжил дээшлүүлэлт, сургалтын арга зүйг шинэчлэх ажлыг хийж байна.

Шинэ арга зүйг нэвтрүүлэх, сургалтын орчныг нь сайжруулах, багш нарыг чадавхжуулахад яамны зүгээс хэрэгжүүлж байгаа АХБ-ны санхүүжилттэй Дээд боловсролын шинэчлэлийн төсөл, Монгол-Японы стратегийн түншлэлийн хүрээнд хэрэгжиж байгаа “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл, Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургуулийн төсөл бусад хөтөлбөрүүд тодорхой үр дүнгүүд өгч байна.

Ялангуяа инженерийн боловсролын чанарыг дээшлүүлэх, инженер технологийн мэргэжилтний шинэ үеийг бэлтгэхэд Япон, Герман улстай хэрэгжүүлж байгаа хамтын ажиллагаа ихээхэн түлхэц болж байна.

### **Боловсролын магадлан итгэмжлэлийг сайжруулах ажлын хүрээнд:**

Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн үйл явц хэт удаашралтай, үр нөлөө нь амьдралд бодитой харагдахгүй, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь нийт ард иргэдэд боловсролын чанар, магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын талаар мэдээлэл маш муу хүргэдэг зэрэг асуудлууд байсныг сайжруулах зорилт тавьсан. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхээр чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж их, дээд сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын

байгууллагууд чанараа зөвхөн хөндлөнгөөр үнэлүүлэх биш, өөрөө өөрийгөө дотооддоо үнэлж, сайжруулдаг чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлэн хэвшүүлэхийг чухал гэж үзэж байгаа.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хяналт шалгалтын шинжтэй үйл ажиллагаанаас чанарын баталгаажилтын ажиллагаа болгохоор ажиллаж байна.

Магадлан итгэмжлэх үйл явцын зохицуулалт, үр нөлөө, энэ ажлыг эрхлэх байгууллагын эрхзүйн байдлыг тодорхой болгох, олон улсад нийтлэг мөрдөж буй хэм хэмжээнд нийцүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх нөхцөл бүрдүүлэх нь чухал байна.

Ингэснээр дээд боловсролын чанарын баталгаажуулалтын үр нөлөө, дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагын хараат бус байдал сайжирна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шаардлага, сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг олон улсын түвшинд хүргэхийг зорьж, “Магадлан итгэмжлэх комиссын үйл ажиллагааны журам”, “Шинжээчийн баг томилон ажлуулах журам”, “Хөндлөнгийн үнэлгээ хийх ерөнхий удирдамж”, “Урьдчилсан магадлан итгэмжлэл хийх түр журам”, “Урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага”, “Туршилтын магадлан итгэмжлэл хийх ажлын удирдамж”, “Туршилтын магадлан итгэмжлэл хийх шалгуур, журам”, БМИҮЗ-ийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, Хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн, Ажлын албаны орон тоог тус тус батлаад байна. Мөн “Мэдээлэл, харилцаа холбооны технологи”-ийн, “Хөдөө аж ахуй, загас агнуур, ойн аж ахуй”-н, “Нийгмийн ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй”-н чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийг тус тус байгуулж, бүрэлдэхүүнийг батлан ажиллаж байна.

Сургалтын чанарыг дээшлүүлж, Ази, Номхон далайн бүсийн дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Токиогийн 2011 оны шинэчилсэн конвенцид нэгдэх асуудлаар Хууль зүйн яам, Гадаад харилцааны яамтай хамтран ажиллаж, хуулийн үзэл баримтлалын төсөл боловсруулан хүргүүлсэн. БМИҮЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийг шинэчлэн сайжруулж, батлуулахаар яамдаас санал авч байна.

Манай улсын хувьд чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэхэд сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарал хандуулж байгааг дурдахад таатай байна. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс 2018 оныг “Чанарын дотоод баталгаажуулалтын жил” болгон зарлаж, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог соёл болгон хэвшүүлэх ажлыг эхлүүллээ. “Чанарын соёл-Чанарын дотоод баталгаажуулалт” олон улсын хурал, “Чанарын дотоод баталгаажуулалт” сэдэвт олон улсын сургалтыг тус тус зохион байгуулсан. Их дээд сургуулийн чанарын дотоод баталгаажуулалт, хяналт үнэлгээ хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах, чанарын баталгаажуулалтын тогтолцоог бүх шатны боловсролын байгууллагад нэвтрүүлэх ажил явагдаж байна.

Ялангуяа Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, ЮНЕСКО-ийн үндэсний зөвлөл, ЮНЕСКО-гийн Бангкок дахь төлөөлөгчийн газартай хамтран

ажиллаж, олон улсын аргачлал нэвтрүүлэх ажлыг эрчимтэй явуулж, сургалт зохион байгуулан их, дээд сургуулийн 200 гаруй багш, эрдэмтэн, судлаачид оролцсон.

Их, дээд сургуулийн ангилал, сургалтын хөтөлбөрийн түвшнээс хамааруулан түүнд тавигдах шаардлага, дүрэм журмыг шинэчлэн боловсуулж байна. Энэ хүрээнд докторын хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг Европын стандартад хүргэх ЭРАСМУС+ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл, МУИС, Отгонтэнгэр их сургууль дээр туршиж байна.

Бид олон улсын боловсролын чанарын сүлжээний олон байгууллагатай хамтран ажиллаж байна. Тухайлбал, INQAANE буюу Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагуудын олон улсын сүлжээний үндсэн гишүүн, мөн APQN буюу Ази, Номхон далайн орнуудын чанарын сүлжээ, CPSC буюу Коломбагийн төлөвлөгөө техникийн боловсролын ажилтны коллеги байгууллагуудын үндсэн гишүүн. Европын холбооны (ERASMUS) төслийн хүрээнд докторын хөтөлбөрийн чанарыг сайжруулахад хамтран ажиллаж байна.

### **Боловсролын магадлан итгэмжлэлийн хэрэгжилтийн ажлын хүрээнд:**

2018 оны эхний хагас жилийн байдлаар 35 дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэл явагдаж байна. Нийт 15 сургуулийн 78 сургалтын хөтөлбөрийн /магистрын 5, бакалаврын 73/ магадлан итгэмжлүүлэх өргөдлийг хүлээн авч дүгнэлт гаргасан.

Их, дээд сургуулиуд шинээр сургалтын хөтөлбөр нээхэд хуулийн дагуу урьдчилсан магадлан итгэмжлэл хийж байна. Хуульд заасны дагуу 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхийн өмнө урьдчилсан магадлан итгэмжлэлийг дээд боловсролын сургалтын 24 байгууллагын 88 хөтөлбөрт шинжээчид ажиллаж, 42 хөтөлбөр "урьдчилсан магадлан итгэмжлэлийн шаардлага" хангасан гэсэн дүгнэлт гарсан.

БМИҮЗ-ийн үйл ажиллагааны өөрчлөлт, чанарын баталгаажилтын үндэсний тогтолцоог бэхжүүлэх зэрэг асуудлаар судлаач, шинжээчид, мэргэжлийн зөвлөлийн гишүүд, их, дээд сургуулийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтнуудыг мэргэшүүлэх цуврал сургалтуудыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна.

Тухайлбал, магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ ирүүлсэн сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт шинжээчийн үнэлгээ хийх аргагүй, шинжээчийн үйл ажиллагаа, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын талаар мэдээлэл өгөх, "БМИҮЗ-ийн эрх зүйн орчин", "Мэргэжлийн боловсролын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа" сэдэвт сургалт, БМИҮЗ-ийн шинэ шалгуур, журмыг танилцуулах сургалт болон туршилтын магадлан итгэмжлэлийн танилцуулах сургалт, ХБНГУ-ын ASIIN байгууллагатай хамтран "Олон улсын магадлан итгэмжлэл" сургалт хэлэлцүүлэг, "Чанарын дотоод баталгаажуулалт-Шинжээч оюутан" сургалт, "Чанарын дотоод баталгаажуулалт-Урьдчилсан магадлан итгэмжлэл", Ойн мэргэжлийн холбоодын ажил олгогчдийн төлөөлөгчдийн хүсэлтээр "БМИҮЗ-ийн эрх зүйн орчин", "Магадлан итгэмжлэл хийх үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөлийн оролцоо", "Мэргэжлийн боловсролын байгууллага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаа" сургалт, "Чанарын дотоод баталгаажуулалт 3-их, дээд сургуулийн удирдлага" баталгаажуулалтын үйл

ажиллагааг идэвхжүүлэх, чанарын баталгаажуулалтад мэдээллийн удирдлагын системийг үр дүнтэй хэрэглэх талаар "Чанарын дотоод баталгаажуулалт - Мэргэжлийн зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалт", "Чанарын баталгаажуулалт- шинжээч" зэрэг сургалтуудыг зохион байгууллаа.

Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар (APACC, ACBSP, AWEWPR, ASIIN) нийт 15 сургуулийн 19 сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдээд байна. Үүний зэрэгцээ Монгол Улсын Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл өөрөө олон улсад магадлуулах, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх бэлтгэлээ хангаж эхлэсэн.

Санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор БМИҮЗ-ийн [www.asstop.mn](http://www.asstop.mn) цахим хуудсанд "Шилэн данс" буланг нээж, төсөв гүйцэтгэл, хөрөнгө оруулалт болон шилэн дансны тухай хууль тогтоомжийг байршуулан ажиллаж байна. Олон улсын жишигт нийцүүлэх хөтөлбөрийг чанаржуулах үүднээс Twining program буюу "Ижилсэх түншлэл" хөтөлбөр хэрэгжүүлж, олон улсын жишигт нийцсэн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага, үйл ажиллагааны журамтай болж чадлаа. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг засаглал, санхүүжилтийн хувьд бие даасан хараат бус байх, удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх, хүний нөөцийг менежментийг боловсронгуй болгох, чадавхтай мэргэшсэн шинжээчидтэй байгууллага болоход зөвлөмжийг ASIIN байгууллагаас авч хамтран ажиллаж байна. Сургалтыг олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулж чанарын баталгаажуулалтын талаар сургуулийн удирдлага, мэргэжилтэн багш нар, шинжээчид, зохицуулагчид, ажил олгогчдын төлөөлөл, оюутан шинжээч, олон талын төлөөлийг 3000 гаруй хүмүүст удаа дараагийн давтамжтайгаар хийлээ.

Үүний үр дүнд Монгол Улсын Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл олон улсад нэр хүндээ өсгөх, хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх бэлтгэлээ хангаж эхлэсэн.

БМИҮЗ-ийн ажлын алба өмнө нь зөвхөн хөндлөнгийн үнэлгээ явуулж, байгууллага, хөтөлбөрийг магадлан итгэмжилдэг, хяналтын чиглэлтэй байсан. Тэгвэл одоо үйл ажиллагаагаа сайжруулан, сургуулиудад өөрийнхөө чанарын түвшнийг үнэлж, чанаржуулах соёлыг түгээн дэлгэрүүлэхийг дэмжин ажиллах боллоо.

Хөтөлбөрийнхөө ахицыг олж харж, хөтөлбөрөө магадлуулснаар сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орж чанарын асуудалд дэвшил гарах юм. Дээд боловсролын шинэчлэлийн үр дүн нь салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж буй бүх талын оролцоо, хамтын ажиллагааны үр дүн билээ.

**ХОЁР. Үндсэн багш, боловсон хүчний дутагдалтай, сургалтын болон оюутны дотуур байр байхгүй, номын сан, биеийн тамирын танхим, практик дадлагын байр, мэргэжлийн лаборатори гэх зэрэг оюутныг хөгжүүлэх орчин бүрдүүлээгүй төрийн бус өмчийн их, дээд сургуулиудад яамны зүгээс тавьж буй шаардлага, бодлогын дэмжлэг туслалцаа болон тухайн сургуулиуд сургалтын бааз сууриа бэхжүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тухай**

Засгийн газар шинээр байгуулагдсанаас хойш /2017 оны 10 сар/ сургалтын чанарыг дээшлүүлэх, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй сургуулийн тоог цөөлөх бодлогыг тууштай баримталж байна. Их, дээд сургуулийн тоо хамгийн оргил үедээ 2004-2005 оны хичээлийн жилд 184 хүрч байсан бол 2017-2018 оны хичээлийн жилийн эхэнд 96 хүрсэн байна. Энэ хичээлийн жилд Боловсрол, соёл,

шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/292 дугаар тушаалаар ажлын хэсэг гарч зохих удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж ажилласан. Төрийн бус өмчийн 18 дээд боловсролын сургалтын байгууллагад хяналт, шинжилгээ-үнэлгээ хийснээс 6 сургуулийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох дүгнэлт гарган, 4 сургууль бусад сургуультай нэгдэж, 4 сургуульд хугацаатай үүрэг даалгавар өгөөд байна.

Дээд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.” гэж заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 26 дугаар тушаалын хавсралтаар “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам” батлагдсан.

Ангиллын журмаар өмчийн хэлбэр харгалзахгүй адилхан шаардлага тавьдаг. Уг журмаар багш, сургалтын орчинд тавигдах шаардлагыг тогтоосон бөгөөд цаашид бид хуульд Засгийн газар ангилал дээшлүүлэх, бууруулах журмыг баталдаг байхаар тусгахаар ажиллаж байна. Зарим төрийн бус өмчйн сургуулиуд өөрийн хүч хөрөнгөөр дорвитой хөрөнгө оруулалт хийж, сургуулийн орчноо сайжруулах ажил хийж байна. Тухайлбал, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Эрдмийн их сургууль, Этүгэн их сургууль, Эдийн засгийн үндэсний их сургууль, Мандах их сургууль, Оточ манрамба их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Сити их сургууль, Шинэ анагаах ухаан их сургууль, Шинэ монгол технологийн дээд сургууль, Ач анагаах ухааны их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Их засаг их сургууль, Рояль дээд сургууль зэргийг дурдаж болох юм. Оюутныг хөгжүүлэх орчин бүрдүүлээгүй, хууль журмын шаардлага хангаагүй төрийн бус өмчийн их, дээд сургуулиудад яамны зүгээс тавьж буй шаардлага, бодлогын дэмжлэг туслалцаа болон тухайн сургуулиуд сургалтын бааз сууриа бэхжүүлэх талаар тогтмол анхаарч шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд цаашид ч хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг үргэлжлүүлэх болно.

**ГУРАВ. Чанарын шаардлага хангаагүй, магадлан итгэмжлэгдээгүй их, дээд сургуулиудыг коллеж, мэргэжлийн сургуулийн зэрэглэлтэй болгох чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**

2009 онд батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн 8.1.-д “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасан

Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагыг политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв болгох асуудал түвэгтэй. Учир нь үүсгэн байгуулагчийн өөрийн эрхийн асуудал бөгөөд хөрөнгө оруулалт ихээхэн шаардагдана. Хэрэв үүсгэн байгуулагч хүсэлтээ гаргаж, хууль тогтоомжид заасны дагуу сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байвал хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудал нээлттэй гэж үзэж байна.

**ДӨРӨВ. Элсэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцүүлэн мэргэжлээ зөв сонгох чиг баримжаа, ойлголт олгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон төгсөгчдийн ажил эрхлэлт,**

**ажилгүйдлийн түвшний талаарх судалгаа, үзүүлэлтэд тулгуурлан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ажил олгогч, төрийн бус байгууллагуудтай хэрхэн уялдаа холбоотой хамтран ажиллаж байгаа тухай**

-Манай улсад дээд боловсролтой мэргэжилтний хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны болон хэтийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох, тооцоолох, таамаглах ажил салбарын яамд, Үндэсний хөгжлийн газрын түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан нэгтгэн боловсруулах ажил учир дутагдалтай байна.

Өөрөөр хэлбэл нэгдсэн бодлого, бүртгэл мэдээллийн систем алга байна. Дээд боловсролын тухай хуулинд 2016 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр элсэлтийн хяналтын тоо тогтоох эрхийг их, дээд сургууль, коллежийн Удирдах зөвлөлд шилжүүлсэн нь алдаа болсон. Үүнийг сайжруулах шаардлагатай. Бид одоо боловсруулж буй Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төсөлд энэ талын зохицуулалтыг тусган ажиллаж байна. Мөн ажил олгогч, бизнес, төрийн бус байгууллагын төлөөллийг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд оруулдаг болох талаар төсөлд тусган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссаны дагуу дээд боловсролын чанарыг дээшлүүлэх бодлогын хүрээнд элсэгчдийн түвшинг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар их, дээд сургууль, коллежид 2018-2019 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх үндэсний хэмжээний босго /хэмжээст/ оноог 410-480-аар тогтоолоо.

“Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах” зөвлөх үйлчилгээг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Дээд боловсролын шинэчлэл төслийн захиалгаар “Ай Ар Ай Эм” ХХК хэрэгжүүлсэн. Мэдээллийн тогтолцоог бий болгох чиглэлд Төгсөгчдийг мөшгих судалгаа (ТМС), Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа (АОСХС), Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа (ХЗЗС) хийх аргачлал, зөвлөмжүүд, Сургалтын хөтөлбөр шинэчлэхэд хөдөлмөрийн зах зээлийн судалгааг ашиглах удирдамж, Оюутнуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, чиглүүлэх зөвлөмж, Хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлэх зөвлөмж, Сургалтын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагатай уялдуулахад мэдээллийн тогтолцоог ашиглах талаар зөвлөмж боловсруулан, түгээж 45 удаагийн цуврал сургалт зохион байгуулаад байна. Үр дүнд нь их, дээд сургуулиуд хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой мэдээллийн сантай болж, судалгаанд үндэслэн хөтөлбөрөө шинэчилдэг болсноор хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй төгсөгчдийг бэлтгэн гаргах боломж бүрдэж байгаа.

Эдгээр арга зүй, хэрэглэгдэхүүн, удирдамж зааврыг нэгтгэсэн “Сургалтын үйл ажиллагаа ба хөдөлмөрийн зах зээлийн судалгаа” гарын авлагыг [herp.mn](http://herp.mn) цахим хуудаснаас үзэх боломжтой.

Хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан сургалтын хөтөлбөр боловсруулж, зах зээлийн судалгаа, төгсөгчийн болон ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг явуулж байгаа сайн туршлагатай сургуулийг тогтоож, богино хэмжээний хэвлэлийн мэдээ/бичлэгийг боловсруулсаныг дараах холбоосоор орж үзэх боломжтой:  
<https://wetransfer.com/downloads/94f8d942cf6f97612ae7f4ffeea96bed20180328084051/a4908ac2f3837b7357b174a98bec6b0e20180328084051/17a87a>

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас тогтмол зохион байгуулдаг Боловсролын салбарын нээлттэй хаалганы өдөрлөгт магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрүүдийг сурталчлан танилцууллаа.

Давхардсан тоогоор нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр 400 орчим сурагч, эцэг эхчүүдэд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан. Орхон аймаг, Сэлэнгэ аймаг, Завхан аймаг, Өмнөговь, Дорнод, Дархан уул аймаг, Багануур дүүргийн Засаг даргын тамгын газар, Боловсрол, соёлын газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгчдөд мэргэжил сонголтын мэдээлэл олгох, магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийг сурталчлах сургалт лекцийг 2017 оны 5-р сар, 9-р сар, 2018 оны 4 дүгээр саруудад тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгууллаа.

ЕБС төгсөж буй 15000 орчим суралцагчдад магадлан итгэмжлэгдсэн сургууль, сургалтын хөтөлбөрийн талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн. Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллеж, МСҮТ сонгон суралцахын ач холбогдолыг Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд аймгийн ЕБС төгсөгч 3300 сурагчид танилцууллаа.

2015 оноос зохион байгуулж эхэлсэн "Мэргэжил таны ирээдүйд" арга хэмжээ 2018 оны 5 дугаар сарын 1-13-ны өдрүүдэд Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд аймгуудад амжилттай зохион байгуулагдлаа. 2018 оны 5 дугаар сарын 1,2 –ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Арвайхээр хотноо болсон "Миний сонголт-Миний ирээдүй" өдөрлөгт магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, сургалтын хөтөлбөрүүдээ танилцуулж, эдгээрийг сонгон суралцахын ач холбогдол сэдвээр лекц уншив. Өдөрлөгт ЕБС төгсөгч 600 сурагч тэдний эцэг эх, асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгчид оролцов.

Өдөрлөг, арга хэмжээний мэдээлэл, танилцуулга, магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын хөтөлбөрийн тараах материал зэргийг хөдөөгийн 18 сумдын ЕБС-ийн 900 орчим төгсөгчдөд хүргэх, мэдээлэх ажлыг сургуулийн захиргаатай хамтран үргэлжлүүлэн зохион байгуулав. ЕБС төгсөгчдөд намраас хавар хүртэлх хугацаанд мэргэжил сонголттой холбоотой мөн их дээд сургуулиудын сурталчилгаа маш ихээр хийгддэг ч энэ төрлийн хэрэгтэй мэдээлэл бага байдаг тухай мэдээлэл авсан төгсөгчид эцэг, эхчүүд саналаа хэлж талархал илэрхийлж байлаа.

"Мэргэжил сонголт-2018" өдөрлөгт магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, сургалтын хөтөлбөрүүдээ танилцуулж, эдгээрийг сонгон суралцахын ач холбогдол сэдвээр лекц уншлаа. Өдөрлөгт Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ бүс, Бэлчир бүс, Ерөө бүс, Орхон бүс, Хараа бүс 5 бүсийн ЕБС төгсөгч нийт 1456 сурагч тэдний эцэг эх, асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгчид оролцов.

Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургууль, коллеж, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв сонгон суралцахын ач холбогдол сэдвээр Ховд хотын ЕБС төгсөгч нийт 300 сурагч тэдний эцэг эх, асран хамгаалагчид, багш сурган хүмүүжүүлэгчид мэдээлэл өглөө. Боловсролын шинэчлэл-2018" үзэсгэлэн 2018 оны 4 дүгээр сарын 20-23-ны хооронд МИШЭЭЛ ЭКСПО төв дээр зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэнд Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, сургалтын хөтөлбөрөө сурталчилж оролцлоо. Эх орон телевизийн "Эх орны өглөө" хөтөлбөрт Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг танилцуулах, магадлан итгэмжлэгдсэн сургууль, сургалтын хөтөлбөрөө сурталчилан таниулах



зорилготойгоор 2018 оны 03 дугаар сарын 23 болон 5 дугаар сарын 19-ний өдрийн өглөөний дугаарт оролцлоо.

**-2016-2017 оны хичээлийн жилд 34,681 суралцагч сургуулиа төгссөн .**

**Төгсөгчид(боловсролын зэргээр)**

	Төгсөгчид	Дипломын дээд	Бакалавр	Магистр	Доктор
2012-2013	37,243	1,181	32,234	3,697	131
2013-2014	33,850	259	29,477	3,996	118
2014-2015	35,181	93	29,728	5,254	106
2015-2016	35,889	231	30,663	4,859	136
2016-2017	34,681	495	30,301	3,772	113

Нийт төгсөгчдийн 61.1 хувийг эмэгтэйчүүд, 38.9 хувийг эрэгтэйчүүд бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.57 байна. Энэ нь 100 эрэгтэй төгсөгчид 157 эмэгтэй төгсөгч ногдож байна гэсэн үг юм.

**Дээд боловсролын сургалтын байгууллагыг төгсөгчид (хүйс, боловсролын зэргээр)**

	Дипломын дээд	бакалавр	магистр	доктор
эрэгтэй	26.5%	33.3%	37.1%	45.1%
эмэгтэй	73.5%	60.7%	62.9%	54.9%

Төгсөгчдийн хүйсийн харьцаа зарим мэргэжлийн чиглэлүүдээр эрс ялгаатай байна. Жишээ нь: эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарын төгсөгчдийн 85.0%, боловсролын салбарын төгсөгчдийн 83.0%, нийгмийн халамж, мэдээлэл-сэтгүүл зүй, биологи, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр суралцаж төгсөгчдийн 78.8-81.3 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол компьютер, тээвэр (төмөр зам), барилга-архитектур, бүх төрлийн инженерийн чиглэлээр төгсөгчдийн 72.9-76.6 хувь, цэрэг, цагдаа, аюулгүй байдлын салбарын төгсөгчдийн 82.1 орчим хувь нь эрэгтэйчүүд байна.

Нийт төгсөгчдийн 15.0% нь боловсрол, 5.8% нь урлаг ба хүмүүнлэг, 36.6% нь нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүй, 4.0% нь байгалийн шинжлэх ухаан, 17.5% нь инженер, технологи, барилга-архитектур, 2.4% нь хөдөө аж ахуй, 12.6% нь эрүүл мэнд, нийгмийн халамж, 5.0% нь үйлчилгээний, 1.1% нь бусад салбарт хамаарч байна. Үүнийг өмнөх хоёр хичээлийн жилтэй харьцуулбал: инженер, технологи, барилга-архитектурын салбарын эзлэх хувь 12.7-17.5 хүртэл өсөж, бусад салбарын хувь ойролцоо түвшинд байна. Гэхдээ урлаг ба хүмүүнлэг, нийгэм, эдийн засаг, мэдээлэл-сэтгүүл зүй, бизнес, удирдлага, эрх зүйн салбараар төгсөгчдийн нийт дүнд эзлэх хувь 44.3-40.3 буюу зонхилох хэсэг нь хэвээр байна. 2016-2017 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 32.2 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон гэсэн статистик мэдээ гарлаа. Докторантур төгсөгчид бараг бүхэлдээ (98.2%), магистрантур төгсөгчдийн 74.8 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 38 орчим хувьтай байгаа нь нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсөгчдийн ажил

эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2024/, Инчоны тунхаглалд заасны дагуу төгсөгчдийг өөрөө өөртөө ажлын байр бий болгох ур чадвартай болгож төгсгөх нь чухал байна. Үүний тулд ахлах курсийн хичээлийн агуулга, хөтөлбөрт бизнес төлөвлөлт, аж ахуй эрхлэх ур чадварын хичээлүүдийг оруулахаар ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулж боловсролын түвшин бүрт эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох "Мэргэшлийн үндэсний хүрээ" боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Мөн энэ талаар Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институттэй хамтран ажиллаж, хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаа, ажиллах хүчний судалгаа зэргийг авч албан хэрэгцээнд ашиглаж байна.

Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, төгсөгчдийн чанар, ур чадвар, үр дүнг сайжруулахын тулд сургуулийн хөтөлбөрийн хороонд ажил олгогчдын төлөөллийг оролцуулдаг жишиг тогтоод байна. Дээд боловсролтой бүртгэлтэй ажилгүйчүүдийн тухай мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос тогтмол авч байна.

Ажил олгогч эздийн холбооны гүйцэтгэх захирлыг сайдын дэргэдэх дээд боловсролын бодлогын зөвлөлийн гишүүнээр, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тэргүүнийг Худалдаа, үйлдвэрлэлийн их сургуулийн удирдах зөвлөлийн даргаар ажиллуулж байна. Энэ нь ажил олгогч, бизнес эрхлэгчдийг дээд боловсролой уялдуулах зорилготой юм. Мөн хуульд өөрчлөлт оруулах төсөлд бизнесийн байгууллага, төгсөгчдийн төлөөллийг төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлд оруулж, сургалтын агуулга, төлөвлөгөө боловсруулахаас эхлээд инноваци, судалгааны ажилд татан оролцуулж, сургалт-судалгаа-үйлдвэрлэл, бизнесийн холбоог сайжруулахаар ажиллаж байна.

Хүндэтгэсэн,



Ц.ЦОГЗОЛМАА